

Additional Material collected by Survey Team

ХӨРЛ 001 Нэр мэдэгдэхгүй

1. Шинэ сүмийн (дуганы) байгуулагдсан он цаг, үүсгэн байгуулагчид, нэрийн тухай.

1990-ээд онд шашин шүтлэг орох чөлөөтэй болсон үед 1996 оны эхээр манай Риченлхүмбэ сумын ард иргэд, дархад олон тэдний хандив өргөлөөр сумын ЗДТГ зохион байгуулж Улаанбаатар хотоос нутгийн иргэн идэвхитэй оролцоотойгоор байгуулсан. 1996 оны 6-р сард нээлтээ хийсэн. Харин яг энэхүү дугандаа тухайн үедээ ч, одоо ч нэр өгөгдөөгүй өдийг хүрчээ.

4. Тухайн үедээ ямар ямар ном хурдаг байсан ба лам нарын тухай. Энэ Зөөлөнгийн хүрээг сэргээсэн үү? Эсвэл шинэ үү?

Манай энд байнгын ажилладаг лам байгаагүй. Эрдэнэтээс түр хугацаагаар лам ирж эхэн үедээ ажилладаг байсан. Яг манай энэ дуган бол Зөөлөнгийн хүрээний туурин дээр байгуулагдсан боловч тэр хүрээний үргэлжлэл биш, тэр хүрээг сэргээн байгуулсан явдал бас биш, зөвхөн сүсэгтэн олны өргөл, санаачлагыг сумын ЗДТГ дэмжиж анх энэ газар энэ дуганыг барьжээ.

5В. 1996 оноос хойш үеийн сүм орон нутгийн удирдлага төдийлөн дэмжээгүй ба орон нутгийн энэ дуганыг бурхан номын зориулалтаар сүсэгтэн олонд үйлчлэх хэмжээнд авч явах шашны боловсролтой лам хувраг байхгүй учир үйл ажиллагаа нь сүүлийн 9 жилд бүрэн зогссон.

7. Үндсэн байгууламж болох дуган нь модоор баригдсан Дорно дахины буддын сүм дуганы хийц загварыг агуулсан, дуганы гадуур шургааган хашаатай ердийн галлагаатай зүүхтай. Хашааны үрт 20м, өргөн 12,8м. Дуганы дотор талбайн үрт 7м өргөн 7м жижиг хэмжээний дуган.

Дуганаас баруун урагш 300 м орчим зайд тэгш газарт 2006 онд Улаанбаатар дахь нутгийн бизнесмэний санаачлага, хандиваар 260 сая төгрөг зарцуулж 9 цагаан суварганы суурийн нийт үрт 10, 40м өргөн нь 1,60м, өндөр нь 1м байна. 9 цагаан суварганы голын өндөр суварганы өндөр 3м 60м өндөр, бусад 8 суврага тус бүрийн өндөр 3 метр өндөртэй байна.

Суваргын өмнө талд (голын өндөр суваргын) 1 метрийн голч бүхий хуучин зөвлөлтийн хүрээний хийдийн нэр болох “Ривогэжай гандан найжаллин” хэмээх нэрийг тангад үсгээр бичсэн бичээс бүхий хүрэл сангийн бойпор байрлуулна.